

Татварын эрсдэлийн үнэлгээ, татварын скорингтой холбоотой шинэчлэлүүд

Серги Кобахидзе

Партнер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Ахлах Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ

enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ

enkhsanaa.erdene-ochir@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс

Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар

601 тоот, Улаанбаатар

14200, Монгол улс

Утас : + 976 70009089

Факс : +976 11 322068

www.pwc.com/mn

Монгол Улсын Татварын Алба (МТА) татвар төлөгч бүр өөрийн татварын эрсдэлийн үнэлгээ, татварын скорингоо үзэж танилцах боломжтой шинэ цэсийг цахим татварын системд 2023 оны 6-р сараас нэвтрүүлээ. Энэхүү шинэчлэлтэй холбоотой мэдээллийг та бүхэнд танилцуулж байна.

Татварын эрсдэлийн үнэлгээний ерөнхий зарчим:

2020 оноос хэрэгжиж буй Татварын Ерөнхий Хуулийн дагуу МТА татварын хяналт шалгалтыг эрсдэлд суурилж гүйцэтгэдэг болсон. Улмаар ил тод байдлыг хангаж, мөн татварын эрсдэлээ өөрсдөө удирдаж, татварын скорингийг бууруулахад нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлж бууруулах боломжийг татвар төлөгчдөд олгох зорилгоор татварын цахим системд уг шинэчлэлийг нэвтрүүлсэн байна.

Татварын эрсдэлийн үнэлгээтэй холбоотой хууль тогтоомж:

Хууль	2019 оны 3 сарын 22-ний өдөр батлагдсан Татварын Ерөнхий Хуульд эрсдэлийн удирдлагатай (ЭУ) холбоотой ерөнхий зарчим, ЭУ-ын арга хэмжээг хэрэгжүүлэх үе шат, ЭУ-тай холбоотой журмыг хэн батлах зэрэг зохицуулалтыг тусгасан.
Журам	Сангийн сайдын 2019 оны 12 сарын 31-ний өдрийн 305 дугаар тушаалаар батлагдсан "Татварын албаны ЭУ-ын үйл ажиллагаа, ЭУ-ын Хорооны ажиллах журам"-д эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, удирдах, хянах зэрэг үйл ажиллагааг зохицуулсан.



Ерөнхий эрсдэлийн үнэлгээ (R)-г тооцох томъёо

$$R = a_1 \cdot R_1 + a_2 \cdot R_2 + a_3 \cdot R_3 + a_4 \cdot R_4 + a_5 \cdot R_5$$

$a_{(1,2,3,4,5)}$ - Үзүүлэлт тус бүрт хамаарах хувийн жин

Ерөнхий эрсдэлийн үнэлгээг диаграммд харуулсан 5 хүчин зүйлсийг холбогдох хувийн жингээр нь үржүүлэн нийлбэрийг гаргах замаар тооцох ба дараах байдлаар тодорхойлно:

0 < эрсдэлийн оноо ≤ 25 бол "Хүлээн зөвшөөрөх"

25 < эрсдэлийн оноо ≤ 50 бол "Бага"

50 < эрсдэлийн оноо ≤ 75 бол "Дунд"

75 < эрсдэлийн оноо ≤ 100 бол "Өндөр"


Татвар төлөгч бүр ерөнхий эрсдэлийн үнэлгээгээ цахим татварын системээсээ харж танилцах боломжтой.

Ерөнхий эрсдэлийн үнэлгээнд тухайн байгууллагын үйл ажиллагааны бүртгэл тайлагналтай холбоотой хүчин зүйлсээс гадна салбарын эрсдэлийн дундаж, хөндлөнгийн мэдээлэл зэрэг бусад хүчин зүйлсийг авч үзэж буйгаараа онцлогтой ба үүнд МТА хиймэл оюун ухааныг ашиглаж буйгаа мэдээлсэн.

Дээрх 5 хүчин зүйлсээс татварын эрсдэлийн үнэлгээ, татварын скорингийн талаар дэлгэрүүлж дараагийн Слайдаас танилцана уу.



Татварын эрсдэлийн үнэлгээ, татварын скорингтой холбоотой дэлгэрүүлэн тодруулах зүйлс байгаа бол эсхүл танд мэргэжлийн туслалцаа хэрэгтэй бол бидэнтэй холбогдоно уу.



(R₁) Татварын эрсдэлийн үнэлгээ

r₁, r₂: ТНО болон Хасагдах зардалд суурилсан дэд оноо

МТА байгууллагуудыг 4 сегмент (том, дунд, жижиг, бичил) хуваан авч үзэж байгаа ба улмаар татвар ногдох орлого, хасагдах зардлын дүнг харгалзан сегмент, эдийн засгийн салбарын ангилал дотор нь эрэмбэлсэн. /Их орлоготой бол их оноотой гэсэн логиктой/

r₃: Зөрүүд суурилсан дэд оноо

Татварын тайлангуудаар тайлагнасан дүнгүүдийн хоорондын зөрүү их байх тусам энэ оноо их гарна гэсэн логиктой. Мөн доорх эх сурвалжаас авсан хөндлөнгийн мэдээллийг ашиглана:
 - Санхүүгийн тайлан
 - Төлбөрийн баримт
 - Гаалийн мэдээ

r₄: Санхүүгийн шинжилгээнд суурилсан дэд оноо

Том сегментийн татвар төлөгчийн санхүүгийн тайланд үндэслэн дараах харьцаануудыг тодорхойлон зэрэглэл тогтооно:
 а. Санхүүгийн тогтвортой байдал
 б. Төлбөрийн чадвар

r₅: Регрессийн шинжилгээнд суурилсан дэд оноо

Бүртгэл, тайлагнал, төлөлт, хяналт шалгалтын түүхэн мэдээлэлд үндэслэж регрессийн шинжилгээ хийгдэж байгаа. Хяналт шалгалтын актын үр дүнг үндэслэн магадлалын утга эрсдэлийн оноог тооцно.

r₆: Салбарын дундаж үзүүлэлтэд суурилсан дэд оноо

Татвар төлөгчийн татварын өмнөх ашгийн түвшин болон бодит татварын хувь хэмжээг тухайн татвар төлөгчийн эдийн засгийн салбарын дундаж түвшний хазайлтыг ашиглан тооцно.

✔ "Татварын эрсдэлийн үнэлгээ" нь татвар төлөгчид ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг үнэлж буй үзүүлэлт ба дараах томъёогоор тооцно.
 $R_1 = a_1 \cdot r_1 + a_2 \cdot r_2 + a_3 \cdot r_3 + a_4 \cdot r_4 + a_5 \cdot r_5 + a_6 \cdot r_6$

(R₂) Татварын скоринг



Татварын скоринг нь татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийн мөрдөлтийг үнэлэх ба зүүн талын диаграммд харуулсан 6 хүчин зүйлсийн сүүлийн 3 жилийн үр дүнг үндэслэн тодорхойлно.

Үнэлгээний тайлбар:

- **A (90 – 100 оноо)** үнэлгээ нь татвар төлөгчийн нэр хүндийн баталгаа болно.
- **B (80 – 90 оноо)** үнэлгээ
- Хэрэв тухайн байгууллага тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй болон сүүлийн 4-н жил ТНО-гүй байсан бол автоматаар **C (70 – 80 оноо)** үнэлгээ авна.
- Групп компаниудын хувьд нэг гишүүг компани **D (0 – 70 оноо)** үнэлгээ авбал тухайн групп тэр чигтээ **D** үнэлгээ авна.
- **D** үнэлгээ авсан байгууллага татварын хяналт орох магадлал өндөр болно.

➔ **(D Үнэлгээ авбал дараагийн 3 жилдээ A үнэлгээ авахгүй)**

Татварын скорингийн үнэлгээг нийт **106** оноос эхлэн тооцох ба шалгуурын бүлэг тус бүрийн хувьд хасаж тооцох хамгийн өндөр оноог хүснэгтээс харна уу.

Татвар төлөгчийн бүртгэл	-11
Татварын тайлагнал	-38
Татвар ногдуулалт	-10
Татвар төлөлт	-16
Хяналт шалгалт	-5
Өмнөх жилийн үнэлгээ	-11
Санхүүгийн тайлан	-15

Татварын скоринг, татварын эрсдэлийн үнэлгээгээ сайжруулж, зохистой удирдахын тулд татвар төлөгч татварын хууль тогтоомжийг зохистой мөрдөж, татвар ногдлоо үнэн зөвөөр тооцож, татварын тайланг хугацаанд нь тайлагнаж, татвараа хугацаанд нь төлж байх хэрэгтэй юм.



Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.
 © 2023 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэлэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.